



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2026 оны 04 сарын 03 өдөр

Дугаар А/233

Булган сум

Эрдэнэбилэгийн Эрболдод сургалтын төлбөрийн дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1.1 дэх заалт, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны XI/03 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албаны хүний нөөцийг 2023-2028 онд хөгжүүлэх хөтөлбөр”, аймгийн Засаг даргын 2026 оны “Хөтөлбөр, төлөвлөгөө, арга хэмжээний зардлыг батлах тухай” А/97 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын тамгын газрын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах албаны зураглаач, эвлүүлэгч Эрдэнэбилэгийн Эрболд нь Глобал удирдагч Их сургуульд Эрх зүйч мэргэжлээр суралцаж байгаа тул сургалтын төлбөрийн зардалд 7,000,000 (долоон сая) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Сургалтын төлбөрт шаардагдах зардлыг аймгийн “Хүний нөөцийг хөгжүүлэх хөтөлбөр”-ийн зардлаас гаргахыг Аймгийн Засаг даргын тамгын газрын дарга (Д.Эрдэнэбилэг)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА Д. ПҮРЭВ-ОЧИР



6326010311